

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа
илэрхийлэлд олон улсын хүний эрх, эрх зүйг
хэрэглэх зарчмууд

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

Англи хэлнээс орчуулсан:

Н.Анараа

Г.Ган-Эрдэнэ

Ц.Отгонбаатар

	Жогжакартын зарчмуудын тухай	5
	Удиртгал	8
Зарчим 1	Бүх хүн хүний эрхээ эдлэх эрхтэй	10
Зарчим 2	Эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид орших эрх	10
Зарчим 3	Хуулийн этгээд байх эрх	12
Зарчим 4	Амьд явах эрх	13
Зарчим 5	Халдашгүй байх эрх	13
Зарчим 6	Хувийн нууц, халдашгүй байдлын эрх	14
Зарчим 7	Эрх чөлөөгөө дур зоргоор хязгаарлуулахаас ангид байх эрх	15
Зарчим 8	Шударга шүүхээр шүүлгэх эрх	16
Зарчим 9	Түр саатуулагдахдаа хүнлэг харьцаагаар хангагдах эрх	17
Зарчим 10	Эрүүдэн шүүх ба харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс ангид байх эрх	18
Зарчим 11	Хүн худалдаалах болон хүнийг мөлжих бүх хэлбэрээс хамгаалагдах эрх	19
Зарчим 12	Ажил хөдөлмөр эрхлэх эрх	20
Зарчим 13	Нийгмийн халамж үйлчилгээгээр хангагдах эрх	20
Зарчим 14	Шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх эрх	21
Зарчим 15	Шаардлага хангахуйц орон байртай байх эрх	21
Зарчим 16	Сурч боловсрох эрх	23
Зарчим 17	Эрүүл мэндийн байж болох дээд жишгийн үйлчилгээг хүртэх эрх	24

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

Зарчим 18	Эрүүлийг хамгаалах салбарын буруу, зохисгүй үйлдлээс хамгаалагдах эрх	25
Зарчим 19	Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх	26
Зарчим 20	Тайван замаар эвлэлдэн нэгдэх эрх	28
Зарчим 21	Итгэл үнэмшил, сүсэг бишрэлтэй байх, шашин шүтэх эрх	29
Зарчим 22	Чөлөөтэй зорчих эрх	29
Зарчим 23	Орогнол хүсэх эрх	30
Зарчим 24	Гэр бүл үүсгэх эрх	30
Зарчим 25	Олон нийтийн амьдралд оролцох эрх	32
Зарчим 26	Соёлын амьдралд оролцох эрх	32
Зарчим 27	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих эрх	33
Зарчим 28	Гомдол хохирлоо барагдуулах эрх	34
Зарчим 29	Хариуцлага	35
	Нэмэлт зөвлөмж	36
	Жогжакартын зарчмуудад гарын үсэг зурсан хүмүүс	39

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУДЫН ТУХАЙ

Бүх хүн тэгш эрх чөлөөтэй төрдөг ба нэр төр, эрхийн хувьд ч эн тэнцүү байдаг. Бүх хүний эрх түгээмэл, хоорондоо харилцан хамааралтай, уялдаатай, хуваагдашгүй. Бэлгийн чиг баримжаа¹, хүйсийн баримжаа илэрхийлэл² нь хүн бүрийн нэр төр, хүний мөн чанарын салшгүй нэг хэсэг байдаг утгаараа ялгаварлан гадуурхалт, хүчирхийллийн үндэс болох ёсгүй.

Хүн бүрийн эдлэх ёстой эрх тэгш нэр төр, хүндэтгэлтэй амьдрах эрхийг бүх бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүст хангах тал дээр олон ахиц дэвшил гараад байна. Олон улс орон хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хувьд эрх тэгш байдал, ялгаварлалд өртөхгүй байх эрхийг баталгаажуулсан үндсэн хууль, хууль тогтоомжтой болжээ.

Хэдий тийм ч хүмүүсийн жинхэнэ ба үзэгдэх бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэн эрхэд нь халдах үзэгдэл бүх улс орныг хамарсан, сэтгэл эмзэглэм ноцтой асуудал болоод байна. Эдгээр зөрчилд шүүхийн гадуур, өчиггүй, зоргоор цаазлах, эрүү шүүлт, хэрцгий хүнлэг бус хандлага, бэлгийн хүчирхийлэл ба хүчин, хувийн орон зайд нь халдах, дур зоргоор саатуулах, хөдөлмөр эрхлэх болон сурч боловсрох эрхийг нь хөсөрдүүлэн үл хангах, бусад эрхээ эдлэхэд нь ялгаварлах гэсэн ноцтой үзэгдлүүд багтаж байна. Түүний хажуугаар эдгээр зөрчил нь арьс үндэс, нас, шашин шүтлэг, бие эрхтэний хөгжил, эдийн засаг, нийгмийн гарал болон бусад байдалд үндэслэсэн олон төрлийн хүчирхийлэл, үзэн ядалт, ялгаварлан гадуурхалт, үл оролцуулах зэрэгтэй ихэнх тохиолдолд давхар үйлдэгддэг.

Олон улс оронд хүмүүсийн хүйсийн болон бэлгийн чиг баримжаа, илэрхийллийн хэм хэмжээг зан заншил, хууль, хүчирхийллээр зохицуулахыг оролддог ба хүмүүс хувийн харилцаагаа хэрхэн мэдэрч, өөрсдийгөө хэрхэн тодорхойлж буйд хяналт тавихыг зорьдог. Хүний бэлгийн мөн чанарыг цагдан хязгаарлах нь жендэрт үндэслэсэн хүчирхийлэл болон хүйсийн эрх тэгш бус байдал үргэлжилсээр байгаад нөлөөлж буй гол хүчин зүйлийн нэг хэвээр байна.

Олон улсын тогтолцоо нь хүйсийн эрх эгш байдал ба нийгэм, олон

1 “Бэлгийн чиг баримжаа” нь эсрэг, ижил, эсвэл нэгээс илүү хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх хүн бүрийн гүн гүнзгий мөн чанар, чадвар юм.

2 “Хүйсийн баримжаа илэрхийлэл” нь хүн бүр хувь хүнийхээ үүднээс өөрийн хүйсээ төрөхөд өгөгдсөн хүйстэйгээ адилаар эсвэл өөрөөр гүн гүнзгий мэдрэх мэдрэмж ба өөрийн биеийн тухай мэдрэмж (үүнд чөлөөт сонголтонд үндэслэн биеийнхээ үзэгдэх байдлыг эм, хагалгаа болон бусад байдлаар өөрчлөх өөрчлөлт багтана), хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөн гэх мэт хүйсийн бусад илэрхийллийг багтаадаг.

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

нийт, гэр бүл дэх хүчирхийллээс ангид байх хамгааллыг бий болгоход нэлээд хувь нэмэр оруулсан. Түүнчлэн НҮБ-ын хүний эрхийн гол механизмууд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхахаас бүх хүнийг үр дүнтэй хамгаалах үүргийг улс орнуудад даалгаж өгсөн билээ. Хэдий тийм ч, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн хүний эрхийн зөрчлийн талаарх олон улсын хариу арга хэмжээ дутуу дулимаг, нэг мөр бус байна.

Энэхүү байдлыг өөрчлөхийн тулд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хувьд олон улсын хүний эрхийн эрх зүйн бүхий л тогтолцоо, түүний механизмуудыг хэрхэн хэрэглэх талаар цогц ойлголтыг бүрдүүлэх хэрэгтэй болсон юм. Эрх тэгш байдал, ялгаварлан гадуурхалтаас ангид бүх хүний бүх эрхийг ханган хамгаалах, ханган хамгаалахыг хөхиүлэн дэмжихийн төлөө олон улсын хүний эрхийн хуулийн дагуу улс орнуудын үүргийг нэг мөр тодорхойлох, нэгтгэх нь амин чухал асуудал байв.

Хүний эрхийн байгууллагуудын эвслийг төлөөлөн “Эрх зүйчдийн олон улсын хороо” ба “Хүний эрхийн төлөө олон улсын үйлчилгээ байгууллага” нь улс орнуудын хүний эрхийн үүрэг хариуцлагыг тодруулан нэгтгэхийн тулд олон улсын эрх зүй, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хэрхэн авч үздэг талаар олон улсын эрх зүйн зарчмуудыг нэгтгэх төсөл хэрэгжүүлсэн юм.

Эдгээр зарчмыг нэр хүнд бүхий хүний эрхийн шинжээчдийн бүлэг боловсруулан хэлэлцэж батласан юм. Индонези Улсын Жогжакарта хот дах Гажа Мада Их сургуль дээр 2006 оны 11-р сарын 6-наас 9-ний хооронд олон салбарын хүнийн эрхийн эрх зүйн асар их туршлагатай 25 орны 29 нэр хүнд бүхий шинжээчид хуралдсаны эцэст Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэглэх Жогжакартын зарчмуудыг санал нэгтгэйгээр баталлаа.

Уулзалтын илтгэгчээр ажилласан Профессор Майкл О’Фларети эдгээр зарчмыг боловсруулах, эцэслэхэд маш их хувь нэмэр оруулсан билээ. Түүний уйгагүй хичээл зүтгэл энэ үйл явцын амжилтад шууд нэмэрлэлээ.

Жогжакартын зарчмууд нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн хувьд хүний эрхийн өргөн хүрээний жишиг хэм хэмжээ, тэдгээрийн хэрэглээг тогтоолоо. Эдгээр зарчим нь улс орнуудын анхдагч үүрэг болох хүний эрхийг хэрэгжүүлэх үүргийг дахин бататгалаа. Зарчим бүрт улс орнуудын хэрэгжүүлвэл зохих зөвлөмж дагалдаж

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

буй ч шинжээчид нь хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэх үүрэг бүх хүн, байгууллагад оногддогийг цохон тэмдэглэж байна. Нэмэлт зөвлөмжүүд нь НҮБ-ын хүний эрхийн тогтолцоо, үндэсний хүний эрхийн тогтолцоо, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн бус байгууллагууд болон санхүүжүүлэгчдэд чиглэсэн юм.

Жогжакартын зарчмууд бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тухай олон улсын хүний эрхийн эрх зүйг бүрэн тусгасан гэдэг дээр бид санал нэгдэж байна. Хүний эрхийн эрх зүй хөгжихийн хэрээр улс орнууд эдгээр зарчим дээр нэмэлт үүрэг хүлээх боломжтойг мөн хүлээн зөвшөөрч байна.

Жогжакартын зарчмууд нь бүх улс орон биелүүлэх ёстой олон улсын эрх зүйн жишиг юм. Эдгээр зарчим нь эрх, эрх чөлөө, нэр төрийн хувьд ижил төрсөн төрөлхийн тэр нандин эрхээ хүн бүр эдлэх гэрэлт ирээдүйг амлана.

Соня Онуфер Коррея

Хамтран тэргүүлэгч

Витит Мунтарборн

Хамтран тэргүүлэгч

ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЭРХ ЗҮЙ
БА БЭЛГИЙН ЧИГ БАРИМЖАА, ХҮЙСИЙН
БАРИМЖАА ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН УЛСЫН
ШИНЖЭЭЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН БИД

УДИРТГАЛ

Бүх хүн эрх чөлөөтэй, нэр төр, эрхийн хувьд тэгш төрдгийг, мөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний эсвэл нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрөлхийн болон бусад байдлаас үл хамааран ямарваа ялгаварлалгүйгээр хүн бүр хүний эрхээ эдлэх эрхтэйг **САНАН**

Хүмүүс бэлгийнхээ чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн дэлхийн өнцөг булан бүрт хүчирхийлэл, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, үл оролцуулах, мухраар буруу ойлгох явдалд өртөж байгаад, эдгээр нь хүйс, арьс үндэс, нас, бие эрхтэний хөгжил, эрүүл мэнд болон эдийн засгийн байдал гэх мэт бусад төрлийн ялгаварлан гадуурхалттай давхар явагдаж байгаад, энэхүү хүчирхийлэл, гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалт, үл оролцуулах, мухраар буруу ойлгох явдал нь ийн зөрчигдсөн хүмүүсийн нэр төр, сүр жавхааг үгүйсгэн, тэдний өөрийн үнэлэмж, өөрийгөө нийгмийнхээ нэг хэсэг хэмээн үзэх үзлийг багасган, хэн гэдгээ нуух, эсвэл үгүйсгэх, амьдралаа айдас дунд үл үзэгдэх байдлаар амьдрахад хүргэж болзошгүйд **СЭТГЭЛ ЗОВНИН**

Жинхэнэ эсвэл үзэгдэх лесбиян, гей эсвэл бисексуал байдлаасаа, харилцан зөвшилцлийн үндсэн дээр ижил хүйсийн хүмүүстэйгээ бэлгийн харилцаанд орж байгаагаасаа, эсвэл жинхэнэ эсвэл үзэгдэх транссексуал, трансжэндэр эсвэл интерсекс байдлаасаа, эсвэл тодорхой нийгмүүдэд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хэмээн үзэгддэг нийгмийн бүлэгт хамаарах хамаарлаасаа тэдгээр хүмүүсийн хүний эрх нь зөрчигдөж байгааг **МЭДЭН**

“Бэлгийн чиг баримжаа” нь эсрэг, ижил, эсвэл нэгээс илүү хүйсийн хүмүүст сэтгэл, хайр дурлал, бэлгийн хувьд татагдах болоод тэдэнтэй дотно ба бэлгийн харилцаа үүсгэх хүн бүрийн гүн гүнзгий мөн чанар, чадвар гэдгийг **ОЙЛГОН**

“Хүйсийн баримжаа илэрхийлэл” нь хүн бүр хувь хүнийхээ үүднээс төрөхөд өгөгдсөн хүйстэйгээ адилаар эсвэл өөрөөр өөрийн хүйсээ гүн гүнзгий мэдрэх мэдрэмж ба өөрийн биеийн тухай мэдрэмж (үүнд чөлөөт сонголтоор биеийнхээ үзэгдэх байдлыг эм, хагалгаа болон

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

бусад замаар өөрчлөх өөрчлөлт багтана), хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөн гэх мэт хүйсийн бусад илэрхийллийг багтаадгийг **ОЙЛГОН**

Олон улсын хүний эрхийн эрх зүй нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн бүр хүний бүх эрхээ бүрэн эдлэх эрхтэйг батласныг үзээд, одоо байгаа хүний эрх нь өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн тодорхой нөхцөл байдлыг хамаарч үзэх ёстойг, хүүхдийн эрх ашгийг тогтоохдоо хүүхдэд хамгийн сайн сайхан байдлыг гол шалгуур болгох ёстойг, хувийн үзэл бодол төлөвшүүлэх чадамжтай хүүхэд өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэйг, хүүхдийн нас, хөгжилд нь тааруулан тэр үзэл бодолд нь зохих ач холбогдол өгөх ёстойг **АНХААРАН**

Олон улсын хүний эрхийн эрх зүй нь бүх хүний эрх, иргэний, соёлын, эдийн засгийн, улс төрийн ба нийгмийн эрхээ эдлэх тухайд ялгаварлан гадуурхалтыг бүрмөсөн хориглодгийг, бэлгийн эрх, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хүндэтгэх нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг бүрдүүлэхийн үнэмлэхүй хэсэг гэдгийг, аль нэг хүйсийн давуу эсвэл дутуу байдлын тухай болон эрэгтэй ба эмэгтэй хүмүүсийн үүрэг ролийн тухай хэвшмэл ойголт үзэл дээр үндэслэсэн буруу ойлголт, зан заншлыг устгах асуудал дээр улс орнууд арга хэмжээ авах үүрэгтэйг, олон улсын нийгэмлэг хүн өөрийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд гэхчилэн өөрийн бэлгийн холбогдолтой асуудлыг шахалт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид чөлөөтэй, хариуцлагатайгаар шийдэх эрхтэйг хүлээн зөвшөөрснийг **ЦОХОН ТЭМДЭГЛЭН**

Өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн амьдралд олон улсын хүний эрхийн хуулийг системчилсэн байдлаар хэрэглэх нь нэн чухлыг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨН**

Энэхүү хэрэглээ нь олон улсын хүний эрхийн эрх зүйн өнөөгийн байдал дээр үндэслэж байгааг, цаашдаа өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн амьдралын туршлага, тэдний амьдардаг бүс нутаг, улс оронд эдгээр хүний эрхийг хэрхэн хэрэгжүүлж байгаагаас үүдэн энд заасан хүний эрхийг хөгжүүлж, цаашид ч боловсронгуй болгох ёстойг **ОЙЛГОЖ**

2006 ОНЫ 11-Р САРЫН 6-9-НИЙ ХООРОНД
ИНДОНЕЗИЙН ЖОГЖАКАРТАД ХУРАЛДСАН
ШИНЖЭЭЧДИЙН УУЛЗАЛТААР ДАРААХ
ЗАРЧМУУДЫГ БАТАЛЛАА. ҮҮНД:

ЗАРЧИМ

1

**БҮХ ХҮН ХҮНИЙ ЭРХЭЭ
ЭДЛЭХ ЭРХТЭЙ**

Бүх хүн тэгш, эрх чөлөөтэй төрдөг ба нэр төр, эрхийн хувьд эн тэнцүү байна. Бүх бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүс хүний эрхээ бүрэн эдлэх эрхтэй.

Улс орнууд:

А. Бүх хүний эрхүүд нь түгээмэл, хоорондоо харилцан хамааралтай, хуваагдашгүй болох зарчмыг үндэснийхээ Үндсэн хууль эсвэл бусад холбогдох хууль эрхийн тогтоомждоо бүрэн багтааж, бүх хүний эрхийг хүн бүрт эдлүүлэхийг хангах ёстой.

Б. Эрүүгийн хуулиудаа оролцуулан бүх хууль тогтоомжоо бүх хүн хүний эрхээ эдлэх зарчимтай нийцүүлэн засварлах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран бүх хүн хүний эрхээ эдлэхийг бататган хөхиүлэн дэмжих нийтийг хамарсан боловсрол, кампанит ажлын хөтөлбөр хэрэгжүүлэх ёстой.

Г. Төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явцаа бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг оролцуулан хүний мөн чанарын хоорондоо уялдаа, хамааралтай байдлыг бататгасан олон ургальг үзлийг нэвтрүүлэх ёстой.

ЗАРЧИМ

2

**ЭРХ ТЭГШ БАЙХ, ЯЛГАВАРЛАН
ГАДУУРХАЛТААС АНГИД ОРШИХ ЭРХ**

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлдээ үндэслэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр хүн бүр бүх хүний эрхээ эдлэх эрхтэй. Хүний эрхээ эдлэхэд өөр эрх эдлэхэд нь зөрчил үүсч байгаа эсэхээс үл хамааран хүн бүр хуулийн өмнө тэгш байж, хуулийн хамгаалалтыг тэгш хүртэх эрхтэй. Улс орнууд ийм төрлийн ялагварлан гадуурхалтыг хуулиар хориглох ёстой ба бүх хүн ийм ялгаварлан гадуурхалтаас бүрэн хамгаалагдах эрхийг нь хангах ёстой.

Эрх тэгш байдлын үндсэн дээр бүх хүний эрх, суурь эрх, эрх чөлөөгөө эдлэхийг нь хүлээн зөвшөөрч эдлүүлэхэд зориуд болон зориуд бусаар хуулийн өмнө эрх тэгш байдлыг нь үгүйсгэх, эсвэл дутуу эдлүүлэхэд хүргэх, бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

нь ямарваа байдлаар онцлох, хязгаарлах, илүүчлэх ямарваа үйлдэл нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад багтана. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт хүйс, нас, шашин шүтлэг, бие эрхтэний хөгжил, эрүүл мэндийн ба эдийн засгийн байдалд үндэслэсэн ялгаварлан гадуурхалттай давхар явагдах боломжтой ба ихэнхдээ давхар явагдаж байдаг.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн үндсэн дээр үл ялгаварлан гадуурхах, эрх тэгш байх зарчмыг үндэснийхээ Үндсэн хууль эсвэл бусад холбогдох хууль эрхийн тогтоомждоо бүрэн багтаах ёстой. Эдгээрт хараахан багтаагүй бол нэмэлт засвар, хуулийн тайлбар гэх мэт арга замаар багтааж, эдгээр зарчмыг бүрэн хэрэгжүүлэхийг хангах ёстой.

Б. Харилцан зөвшилцлийн үндсэн дээр насанд хүрсэн ижил хүйсийн хүмүүс хоорондоо бэлгийн харилцаанд орохыг хориглосон, эсвэл хориглох зорилготой ашигладаг эрүүгийн болон бусад хууль тогтоомжийнхоо зүйл ангийг хүчингүй болгож, зөвшилцөх насыг эсрэг болон ижил хүйсийн бэлгийн аль аль хавьталд адил тогтоохыг хангах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг төрийн болон хувийн секторт хориглох, устгахын тулд тохирох эрх зүйн болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Г. Өөр өөр бэлгийн чиг баримжаатай, эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүс хүний эрхээ бүрэн дүүрэн эдлэхийг хангахад шаардагдах, эдгээр хүмүүс хангалттай өсөн дэвжихийг нь хангахын тулд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Ийм төрлийн арга хэмжээ нь ялгаварлан гадуурхалт хэмээн тооцогдохгүй.

Д. Бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтын эсрэг авах бүх хариу үйлдэлдээ ийм төрлийн ялгаварлан гадуурхалт нь бусад төрлийн ялгаварлан гадуурхалттай хэрхэн уялдаж байгааг хамтад нь авч үзэх ёстой.

Е. Аль нэг бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл нь нөгөөгөөсөө илүү, эсвэл дутуу гэсэн үзлээс үүдэлтэй ялгаварлах хандлага, зан үйлийг таслан зогсоох зорилготой сургалт мэдээллийн хөтөлбөр гэх мэт холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

ХУУЛИЙН ЭТГЭЭД БАЙХ ЭРХ

Хүн бүр хаана ч хуулийн этгээд хэмээн зөвшөөрөгдөх эрхтэй. Өөр өөр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүс амьдралынхаа бүх салбарт хуулийн этгээд байх эрхийг эдлэнэ. Хүн бүрийн өөрийгөө тодорхойлсон бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл нь тэдний хувь хүний мөн чанарын салшгүй хэсэг ба өөрийн мөн чанараа тодорхойлох, нэр төр, сүр жавхаа, эрх чөлөөтэй байхын хамгийн үндсэн хэсэг мөн. Хүйсийн баримжаа илэрхийллээ хуулиар зөвшөөрүүлэхэд хүйс шилжих хагалгаа, үргүй болгох, дааврын эмчилгээ гэх мэт эмнэлгийн ажилбарт орсон байхыг хэнд ч хүчээр тулгах ёсгүй. Хүний хүйсийн баримжаа илэрхийллийг хуулиар хүлээн зөвшөөрөхөд гэрлэлтийн байдал, эцэг эх байгаа байдал гэх мэт ямарваа байдлыг нь харгалзах ёсгүй. Хэнийг ч өөрийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээ нуух, дарагдуулах, үгүйсгэхийг тулгах ёсгүй.

Улс орнууд:

А. Иргэний асуудал дээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр нь ялгаварлалгүй бүх хүн хуулийн этгээд байх, гэрээ хэлэлцээр хийх, өмч захиран зарцуулах, өмчлөх, эзэмших, гэрээслэлээр хөрөнгө өвлөхийг оролцуулан өмчтэй болох гэх мэт эрхээ хүн бүр эдлэх боломжийг олгох ёстой.

Б. Хүн бүрийн өөрийгөө тодорхойлдог хүйсийн баримжаа илэрхийллийг бүрэн дүүрэн хүндэтгэх, хуулиар хүлээн зөвшөөрөхөд шаардагдах бүх эрх зүйн, захиргааны болон бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Төрөөс гаргадаг хүйс заасан төрсний гэрчилгээ, паспорт, үнэмлэх, сонгуулийн хуудас болон бусад биеийн байцаалт баримт бичиг нь хүний өөрийгөө тодорхойлдог хүйсээр өгөгдөхийг хангах бүх процедур байгааг эрх зүйн, захиргааны болон бусад холбогдох арга хэмжээгээр хангах ёстой.

Г. Ийм процедур нь хурдан, шударга, үл ялгаварласан ба холбогдох хүний нэр төр, хувийн нууцлалыг хүндэтгэсэн байхыг хангах ёстой.

Д. Хууль эсвэл бодлогоор хүмүүсийг хүйсээр нь тодорхойлох, хүйсээр нь тусгаарлах бүх нөхцөлд биеийн байцаалт бичиг баримтад орсон өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхийг хангах ёстой.

Е. Хүйсийн шилжилтэд орж буй бүх хүнд нийгмийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

АМЬД ЯВАХ ЭРХ

4

Бүх хүн амьд явах эрхтэй. Хэний ч амь насыг дур зоргоор, тэр дундаа бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн таслах ёсгүй. Зөвшилцөх насанд хүрч, харилцан зөвшилцлийн үндсэн дээр бэлгийн харилцаанд орсноос нь, эсвэл бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс нь болж хүнд цаазаар авах ял оноох ёсгүй.

Улс орнууд:

А. Зөвшилцлийн насанд хүрсэн, харилцан зөвшилцлийн үндсэн дээр ижил хүйсийн хүмүүс хоорондоо бэлгийн харилцаанд орохыг хориглох зорилготой, эсвэл ийм үр дүнд хүргэхүйц бүх төрлийн гэмт хэргийг гэмт хэргийн тооноос хасах, хасталаа ийм заалтын дагуу ял эдлэж буй хүмүүст цаазаар авах ял оноохгүй байх ёстой.

Б. Зөвшилцлийн насанд хүрсэн, харилцан зөвшилцлийн үндсэн дээр бэлгийн харилцаанд орсонтой холбоотой гэмт хэргээр цаазын ял хүлээж буй хүмүүсийн цаазын ялыг болиулж, ийм ял хүлээж буй бүх хүнийг суллах ёстой.

В. Төрийн зүгээс зөвшөөрснөөр, эсвэл төрийн зүгээс даалгаснаар бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн хүмүүсийн амь насанд халдах халдлагыг таслан зогсоох, төрийн албан хаагч эсвэл бусад аливаа хүн, бүлэглэл үйлдсэн бүх ийм халдлагыг нарийн шалгаж, холбогдох нотлох баримт олдсон тохиолдолд буруутай этгээдүүдэд хэрэг үүсгэж, шүүн таслан, шийтгэл оноох ёстой.

ХАЛДАШГҮЙ БАЙХ ЭРХ

5

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран бүх хүн халдашгүй байх эрхтэй ба төрийн албан хаагч эсвэл бусад аливаа хүн, бүлэглэлийн хүчирхийлэл, бие махбодын гэмтлээс төрөөр хамгаалуулах эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хүчирхийлэл, гутсан доромжлолын бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хамгаалалт үзүүлэхэд бүх шаардагдах арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Аливаа хүн эсвэл бүлэг хүнийг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн гэр бүл гэх мэт амьдралын бүх салбарт хүчирхийлэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хүч хэрэглэхэд турхирах гэх мэт бусад хүчирхийллийн хэлбэрт дүйцэх эрүүгийн хариуцлага оноох бүх эрх зүйн арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Золиос болсон хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл нь тухайн хүчирхийллийг зөвтгөх, уучлах, хөнгөрүүлэх үндэслэл болох ёсгүйг хангахын тулд эрх зүйн, захиргааны болон бусад холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Г. Ийм хүчирхийллийг нарийн шалгаж, нотлох баримт олдсон тохиолдолд хариуцах этгээдүүдэд хэрэг үүсгэж, шүүн таслан шийтгэх, хүчирхийллийн золиос болсон хүмүүсийн хохирлыг мөнгөн болон бусад хэлбэрээр шаардлагатай хэмжээнд барагдуулах ёстой.

Д. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн хүчирхийлэл нь ялгаварлан гадуурхалт, хүмүүсийн мэдээлэлгүй байдлаас үүддэг тул үүнтэй тэмцэхийн тулд олон нийтэд чиглэсэн, мөн хүчирхийлэл үйлдэгч, хүчирхийлэл үйлдэх магадлалтай хүмүүст зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх ёстой.

ЗАРЧИМ

6

**ХУВИЙН НУУЦ,
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭРХ**

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн бүр амьдралд нь дур зоргоор оролцох, халдах халдлагад өртөлгүй гэр бүл, орон байр, захидал харилцааны хувьд халдашгүй байх, нэр төр ба нэр хүндэд нь хууль бусаар халдахаас хамгаалагдсан байх эрхтэй. Хувийн нууц, халдашгүй байдлын эрх нь өөрийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн тухай мэдээлэл, өөрийн бие эрхтэний тухай шийдвэр, харилцан зөвшилцлийн үндсэн дээр бусадтай бэлгийн болон бусад байдлаар харилцах тухай сонголтоо илэрхийлэх, эсвэл эс илэрхийлэх сонголтыг дотроо агуулна.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг үл харгалзан хүн бүр хувийн орон зайтай байх, өөрт хамаатай асуудлаараа шийдвэр гаргах, зөвшилцлийн насанд хүрсэн хүмүүс хоорондоо харилцан зөвшилцөн бэлгийн хувьд харилцах харилцаатай

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

байх эрхийг нь хангахын тулд бүх шаардлагатай эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Зөвшилцлийн насанд хүрсэн ижил хүйсийн хүмүүс хоорондоо харилцан зөвшилцлийн үндсэн дээр бэлгийн харилцаанд орж байгааг гэмт хэрэгт тооцсон бүх хууль тогтоомжоо хүчингүй болгож, бэлгийн харилцаанд орох зөвшилцөх насыг эсрэг болон ижил хүйсийн бэлгийн аль аль хавьталд адил тогтоохыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Эрүүгийн болон бусад ерөнхий хуулийн заалтыг зөвшилцлийн насанд хүрсэн ижил хүйсийн хүмүүс хоорондоо харилцан зөвшилцлийн үндсэн дээр бэлгийн харилцаанд орж байгааг де факто гэмт хэрэгт тооцохгүй байхыг хангах ёстой.

Г. Хувцаслалт, үг яриа, биеийн хөдөлгөөнийг багтаан хүний хүйсийн баримжаа илэрхийллийг хориглосон, эсвэл тэр илэрхийллийг нь гэмт хэрэгт тооцсон, эсвэл өөрийн хүйсийн баримжаагаа илэрхийлэхийн тулд биеэ өөрчлөх боломжийг нь үгүйсгэсэн аливаа хуулиа хүчингүй болгох ёстой.

Д. Зөвшилцлийн насанд хүрсэн хүмүүс хоорондоо харилцан зөвшилцлийн үндсэн дээр бэлгийн харилцаанд орсонтой холбоотойгоор, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийнхээ үндсэн дээр саатуулагдсан, хоригдож, эсвэл ял эдлэж буй хүмүүсийг суллах ёстой.

Е. Хүмүүс бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийнхээ талаар мэдээллийг хэзээ, хэнд, хэрхэн нээхээ сонгох эрхийг нь хангаж, тийм мэдээллийг дур зоргоор, эсвэл хүсээгүй байхад нь бусдад задруулах, задруулахаар сүрдүүлэхээс бүх хүнийг хамгаалах ёстой.

ЭРХ ЧӨЛӨӨГӨӨ ДУР ЗОРГООР ХЯЗГААРЛУУЛАХААС АНГИД БАЙХ ЭРХ

ЗАРЧИМ

7

Хэнийг ч дур зоргоор баривчилж, саатуулах ёсгүй. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн хэн нэгийг баривчлан саатуулах нь шүүхийн тогтоол байгаа эсэхийг үл харгалзан дур зоргын үйлдэл болно. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг үл харгалзан баривчлагдсан бүх хүн баривчилгааны шалтгаан болон хэрэг үүсгэгдэж буй шалтгааныг тэгш байдлын үндсэн дээр мэдэх, гэмт хэрэгт буруутгагдсан эсэхийг үл харгалзан шүүхийн тогтоолтойгоор саатуулагдсан нь хууль ёсны үйлдэл мөн эсэх тухай шалгуулах эрхтэй.

Улс орнууд:

А. Бүх шаардлагатай эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээгээр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл нь ямар ч тохиолдолд саатуулах, баривчлах үндэслэл байх ёсгүйг хангах, тэр дундаа ялгаварлалтайгаар хэрэглэж болох, эсвэл бусад байдлаар баривчлахад хүргэхүйц тодорхой бус үгтэй эрүүгийн хуулийнхаа заалтуудыг тодорхой болгох ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг үл харгалзан баривчлагдсан бүх хүн баривчилгааны шалтгаан болон хэрэг үүсгэгдэж буй шалтгааныг тэгш байдлын үндсэн дээр мэдэх, гэмт хэрэгт буруутгагдсан эсэхийг үл харгалзан шүүхийн тогтоолтой саатуулагдсан нь хууль ёсны үйлдэл мөн эсэх тухай шалгуулах эрхийг нь бүх шаардлагатай эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээгээр хангах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл дээр үндэслэсэн ямар ч саатуулга, баривчилгаа нь дур зоргын үйлдэл мөн болох талаар цагдаа болон бусад хууль сахиулагч бие бүрэлдэхүүнийг сурган, мэдээллээр хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

Д. Баривчилгаа болон саатуулгын протоколыг огноо, байршил, саатуулах шалтгааныг багтаан үнэн зөв хөтлөх, хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн баривчилгааг тогтоох чадвартай, үүрэг хүлээсэн байгууллагууд түр саатуулах, урьдчилан хорих газарт орж, хараат бус хяналт явуулах боломжийг нь хангах ёстой.

ЗАРЧИМ

8

ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг нь үл харгалзан хүн бүр өөрийн эрх үүргээ хуулиар тогтоолгох болон гэмт хэрэгт шалгагдаж байгаа тохиолдолд хуулиар тогтоосон, чадварлаг, хараат бус, шударга шүүхээр нийтэд нээлттэй хуралдаанаар шүүлгэх эрхтэй.

Улс орнууд:

А. Хүний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлдог иргэний ба эрүүгийн шүүх ажиллагаа болон бусад шүүх, захиргааны арга хэмжээ тооцох үйл явцын бүх шатанд хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн

баримжаа илэрхийлэл дээр үндэслэн тэдэнтэй ялгаварлан харьцахыг хориглох, тийм байдлыг арилгах, түүнчлэн шүүх хэргийн тал, гэрч, өмгөөлөгч эсвэл шийдвэр гаргагчийн чадвар, төлөв байдлыг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой шалтгаанаар хэрэгсэхгүй болгохыг урьдчилан сэргийлэх үүднээс бүх шаардлагатай эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн ялгаварлан гадуурхалтаас бүхэлдээ эсвэл хэсэгчлэн үүдсэн эрүүгийн болон иргэний шүүн таслах ажиллагаанаас хүнийг хамгаалах бүх шаардлагатай, боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг оролцуулан эрх тэгш байдал, үл ялгаварлах зарчим болон олон улсын хүний эрхийн жишгийн талаар шүүгч, шүүхийн ажилтан, прокурор, хуульч болон бусад хүмүүст зориулж сургалт мэдээллийн хөтөлбөрийг зохион байгуулах ёстой.

ЗАРЧИМ

ТҮР СААТУУЛАГДАХДАА ХҮНЛЭГ ХАРЬЦААГААР ХАНГАГДАХ ЭРХ

9

Эрх чөлөөгөө хасуулсан бүх хүнтэй төрөлхийн нэр төрийг нь хүндлэн хүнлэг харьцана. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл нь хувь хүн бүрийн нэр төрийн салшгүй нэгэн хэсэг мөн.

Улс орнууд:

А. Хүнийг түр саатуулан хорихдоо тухайн хүнийг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн гадуурхах, хүчирхийлэх, түүнтэй зүй бусаар харьцах, бие махбод болон сэтгэл санааны эсвэл бэлгийн хүчирхийллийн эрсдэлд нэмж оруулахгүй байхыг хангах ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн хүмүүсийн тодорхой хэрэгцээг хүлээн зөвшөөрөн, түр саатуулах газар хоригдогсдын хэрэгцээнд нийцсэн нөхөн үржихүйн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ-ын мэдээлэл, эмчилгээ авах, дааврын болон бусад эмчилгээ хүртэх, хүйс шилжилтийн эмчилгээгээр хангагдах зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөгөө хүртэх эрхээр нь хангах ёстой.

В. Боломжийн хэрээр бүх хоригдлуудын бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь тохирсон түр саатуулах газрыг сонгох шийдвэрт тэдний оролцоог хангах ёстой.

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

Г. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа болон илэрхийллийнхээ улмаас хүчирхийлэлд өртөх магадлалтай бүх хоригдлуудыг хамгаалах арга хэмжээ авах, түүнчлэн бусад хоригдлуудын эдлэх эрхтэй харьцуулахад эдгээр арга хэмжээ нь тэдний эдлэх эрхийг хязгаарлахгүй байхыг хангах ёстой.

Д. Хостойгоо уулзах уулзалтыг зөвшөөрдөг л бол хамтрагчийн хүйсийг үл харгалзан бүх хоригдлууд болон түр саатуулагсад хостойгоо уулзахыг эрх тэгш байдлын үндсэн дээр хангах ёстой.

Е. Түр саатуулах байгууламжийг хараат бусаар хянах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагууд, ялангуяа бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн чиглэлээр ажилладаг байгууллагууд хийх боломжийг хангах ёстой.

Ё. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг оролцуулан эрх тэгш байдал, үл ялгаварлах зарчим ба олон улсын хүний эрхийн жишгийн талаар хорих болон түр саатуулах байгуулагад ажилладаг төрийн ба хувийн секторын бүх ажилтнуудад зориулж сургалт мэдээллийн хөтөлбөрүүдийг зохион байгуулах ёстой.

ЗАРЧИМ

10

ЭРҮҮДЭН ШҮҮХ БА ХАРГИС ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БҮЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХЭЭС АНГИД БАЙХ ЭРХ

Хүн бүр ямар ч шалтгаанаар, тэр дундаа бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой шалтгаанаар эрүү шүүлт, харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэлээс ангид байх эрхтэй.

Улс орнууд:

А. Хохирогчийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн эрүү шүүлт ба харгис хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэл, мөн эдгээр үйлдэлд хүргэсэн өдөөн турхиралтаас сэргийлэх, хамгаалахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой үйлдэгдсэн эрүү шүүлт ба харгис хэрцгий, хүнлэг бусаар

буюу хүний нэр төрийг доромжилсон харьцаа, шийтгэлийн хохирогчдыг илрүүлэх, түүнчлэн эрхийг нь сэргээх, хохиролыг нь барагдуулах, шаардлагатай бол эрүүл мэндийн болон сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх зэрэг бүх боломжит арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Эдгээр үйлдлийг үйлдэх эсвэл үйлдэгдэхээс сэргийлэх эрх мэдэл бүхий цагдаа, хорих байгууллага, шоронгийн ажилтнууд болон төрийн ба хувийн секторын бусад бүх хүмүүст зориулж сургалт мэдээллийн хөтөлбөрүүдийг зохион байгуулах ёстой.

ХҮН ХУДАЛДААЛАХ БОЛОН ХҮНИЙГ МӨЛЖИХ БҮХ ХЭЛБЭРЭЭС ХАМГААЛАГДАХ ЭРХ

ЗАРЧИМ

11

Хүн бүр жинхэнэ эсвэл үзэгдэх бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн худалдаалах, бэлгийн болон бусад мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалагдах эрхтэй. Хүн худалдаалахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ нь эмзэг байдлыг хурцатган ихэсгэх хүчин зүйл мөн болох жинхэнэ эсвэл үзэгдэх бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл, эсвэл эдгээр болон бусад илэрхийлэлд үндэслэсэн тэгш бус байдал ба ялгаварлан гадуурхалтыг заавал багтаан авч үзэх ёстой. Эдгээр арга хэмжээ нь хүний наймаанд өртөх эрсдэл бүхий хүмүүсийн хүний эрхийг дээдэлсэн байна.

Улс орнууд:

А. Жинхэнэ эсвэл үзэгдэх бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн хүн худалдаалах, наймаалах, бэлгийн болон бусад мөлжлөгийн бүх хэлбэрээс хүмүүсийг урьдчилан сэргийлэх, хамгаалах шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Эдгээр хууль тогтоомж, арга хэмжээ нь ийм гэмт хэргийн золиос болох магадлалтай хүмүүсийн байдлыг улам доройтуулахааргүй, тэднийг ямарваа байдлаар ялгаварлан гадуурхаагүй, зан үйлийг нь гэмт хэрэгт тооцоогүй байхыг хангах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл зэрэг дээр нь үндэслэн хүний наймаа, бэлгийн болон мөлжлөгийн бүх хэлбэрт хүмүүсийн өртөх эмзэг байдлыг ихэсгэдэг нийгмээс тусгаарлагдах, ялгаварлан гадуурхагдах, гэр орныхон болон уламжлалт олон нийтийнхний үгүйсгэл, санхүүгийн хараат байдал, орон гэргүй байх, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг бууруулдаг ялгаварлан гадуурхах

нийгмийн хандлага, орон сууц, байр, хөдөлмөр эрхлэлт ба нийгмийн үйлчилгээ хүртэхэд ялгаварлагдахаас хамгаалагдсан хамгаалалт зэрэг хүчин зүйлийг авч үзсэн эрх зүйн, боловсрол, нийгмийн арга хэмжээ, үйлчилгээ, хөтөлбөрүүдийг бий болгох ёстой.

ЗАРЧИМ
12

АЖИЛ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЭРХ

Хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр боломжийн, үр бүтээлтэй ажил хөдөлмөр эрхлэх, шударга, таатай ажлын нөхцлөөр хангагдах, түүнчлэн ажилгүйдлээс хамгаалагдах эрхтэй.

Улс орнууд:

А. Мэргэжил эзэмших сургалтад хамрагдах, ажилд авах, албан тушаал дэвших, ажлаас халах, хөдөлмөр эрхлэлтийн ба хөдөлмөрийн урамшууллын нөхцөл зэрэг багтах төрийн болон хувийн сектор дах хөдөлмөр эрхлэлтэд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг хориглох, устгахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгаж, сонгуульт албан тушаал эрхлэх, цагдаа цэрэгт алба хаахыг оролцуулан төрийн албаны бүх салбарт эрх тэгш хөдөлмөр эрхлэлт, эрх тэгш албан тушаал дэвших боломжийг хангаж, ялгаварлан гадуурхах хандлагыг устгахын тулд шаардлагатай сургалт мэдээллийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

ЗАРЧИМ
13

НИЙГМИЙН ХАЛАМЖ БОЛОН БУСАД НИЙГЭМ ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ХАНГАГДАХ ЭРХ

Хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр нийгмийн халамж болон бусад нийгэм хамгааллын үйлчилгээгээр хангагдах эрхтэй.

Улс орнууд:

А. Хөдөлмөрийн нөхцөлийн тэтгэлэг, эцэг эх болсны амралт,

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

ажилгүйдлийн тэтгэлэг, эрүүл мэндийн даатгал болон халамж тэтгэмж, бусад нийгмийн даатгал, гэр бүл болсны тэтгэмж, оршуулгын тэтгэмж, түүнчлэн өвчин буюу үхлийн улмаас гэр бүл, хамтрагчаа алдсаны тэтгэмж гэх мэт нийгмийн халамж хамгааллын бусад арга хэмжээг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлалгүй тэгш хүртэх бүх хүний эрхийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Хүүхдийн өөрийн эсвэл түүний гэр бүлийн аль нэг гишүүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэн хүүхдийг нийгэм хамгааллын тогтолцоонд болон нийгмийн халамж хүртэх явцад нь ялгаварлан гадуурхахгүй байхыг хангах ёстой.

В. Ядуурлыг бууруулах стратеги, хөтөлбөрийн хүрээнд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхалгүй тэгш хүртээхийн тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

ШААРДЛАГА ХАНГАХУЙЦ АМЬЖИРГААНЫ ТҮВШИНТЭЙ БАЙХ ЭРХ

ЗАРЧИМ

14

Хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр тохиромжтой хоол хүнс, аюулгүй ундны ус, зүй зохистой эрүүл ахуй, хувцас хунар зэрэг шаардлага хангахуйц амьжиргааны түвшинтэй байх эрх, мөн амьдралын нөхцөлөө үргэлжлүүлэн дээшлүүлэх эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр нь ялгаварлалгүй, зохих хоол хүнс, аюулгүй ундны ус, зохих эрүүл ахуйн нөхцөл болон хувцас хунараар хүн бүрийг тэгш, хүртээмжтэй хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

ШААРДЛАГА ХАНГАХУЙЦ ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

ЗАРЧИМ

15

Хүн бүр бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр орон гэрээсээ хөөгдөхөөс хамгаалуулах эрхийг багтаан шаардлага хангахуйц орон байртай байх эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл эсвэл гэрлэлт буюу гэр бүлийн байдал дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр, хоргодох байр болон бусад онцгой нөхцөл байдлын орон байр зэргийг оруулан үнийн хувьд боломжийн, амьдрахад тохиромжтой, соёлын хувьд зохистой, мөн аюулгүй байдлыг хангасан орон байртай байх эрх, түүнчлэн орон байр түрээслэх эрхийг нь хамгаалахын тул шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Олон улсын хүний эрхийн хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагад үл нийцсэн байдлаар орон байрнаас албадан нүүлгэх явдлыг хориглохын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой ба бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, эсвэл гэрлэлт буюу гэр бүлийн байдал дээр үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр илүү чанартай, боломжийн газар эзэмших, албадан нүүлгэсэн тохиолдолд шилжин суурьших газраар хангагдах эрхийг багтаан шаардлага хангахуйц орон байртай байх эрх, орон байрнаас албадан нүүлгэхээс хамгаалагдах эрх нь зөрчигдөж байгаа, эсвэл зөрчигдөхөд бэлэн болсон хүмүүсийн төлөө зүй ёсны, үр дүнтэй эрх зүйн болон бусад зохих арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр хүн газар болон байр байшин өмчлөх, тэдгээрийг өвлөх эрхээр тэгш хангагдах ёстой.

Г. Нийгмээс гадуурхах, гэр бүлийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, санхүүгийн хараат байдал болон гэр бүл буюу олон нийтийн хүрээллээс хасах, тэр дундаа хүүхэд, залуучууд орон гэргүй болох зэрэг эмзэг байдалд хүргэх хүчин зүйлсийг авч үзэх, түүнчлэн хөршийн холбоо, харилцан туслалцаа, аюулгүй байдлыг дэмжихийн тулд нийгмийн дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ёстой.

Е. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийнхээ улмаас орон гэргүй болох магадлалтай байгаа, мөн нийгмийн эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүсийн эрэлт хэрэгцээг ойлгох, хэрэгцээг нь хангахын тулд бүх холбогдох агентлагуудад зориулж сургалт мэдээллийн хөтөлбөрүүдийг зохион байгуулах ёстой.

СУРЧ БОЛОВСРОХ ЭРХ

16

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн, эсвэл эдгээрт хамаатай учир шалтгаанаар ялгаварлан гадуурхалтад өртөлгүй сурч боловсрох эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа, эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээрээ ялгаварлан гадуурхалтад өртөлгүй хүн бүрийн боловсролын тогтолцооны хүрээнд сурч боловсрох эрх, тэгш хүртээмжийг хангахын тулд, мөн оюутан сурагч, боловсролын байгууллагын ажилтан болон багш нартай эрх тэгш харьцах харьцааг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Боловсрол нь оюутан сурагч бүрийн хувь хүний шинж чанар, авьяас, оюун ухаан, бие махбодын чадварыг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэсэн, бүх бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл бүхий оюутан сурагчдын хэрэгцээнд нийцсэн байхыг хангах ёстой.

В. Боловсрол нь өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг бодолцсон, эрх тэгш, хүлээцтэй байдал, энх тайван болон харилцан ойлголцлыг хангасан байдлаар хүний эрхийг дээдлэхийг, мөн хүүхэд бүрийн эх эцэг, гэр бүлийн гишүүд, тэдний соёлын илэрхийлэмж, хэл болон соёлын үнэ цэнийг эрхэмлэн дээдлэхийг хөгжүүлэхэд чиглэсэн байхыг хангах ёстой.

Г. Боловсролын арга зүй, сургалтын төлөвлөгөө болон сургалтын бааз нь өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл, тэр дундаа оюутнууд, тэдний эх эцэг болон гэр бүлийн гишүүдийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой тодорхой хэрэгцээг ойлгон хүндэтгэх явдлыг дээшлүүлж буйг хангах ёстой.

Д. Өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй оюутан сурагчид, боловсролын ажилтнууд болон багш нарыг сургуулийн орчинд дээрэлхэх, хүчирхийлэх зэрэг бүх төрлийн байдлаар нийгмээс гадуурхах болон амгалан тайван байдлыг нь алдагдуулах үйлдлээс тэднийг зохистой хэмжээнд хамгаалах хууль дүрэм, бодлоготой байхыг хангах ёстой.

Е. Ийм төрлийн гадуурхалт, хүчирхийлэлд өртсөн оюутан сурагчдыг хамгаалах шалтгаанаар тэднийг улам бүр нийгмээс тусгаарлахгүй байх, эрх ашгийг нь тодорхойлж хэрэгжүүлэхдээ тэдний оролцоог хангах ёстой.

Ё. Боловсролын байгууллагууд оюутан сурагчдыг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр нь ялгаварлан гадуурхаж, түүнд нь үндэслэн тэднийг шийтгэлгүйгээр хүний эрхэд нийцсэн хэлбэрээр сахилга батыг хэвшүүлэхийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Ж. Боловсролын тогтолцооны хүрээнд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртсөн насанд хүрэгчдийг багтаан бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүй хүн бүр насан туршийн боловсрол эзэмших боломж, нөөцөөр хангагдах ёстой.

ЗАРЧИМ 17 ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙЖ БОЛОХ ДЭЭД ЖИШГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРТЭХ ЭРХ

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр бие махбод ба оюун санааны эрүүл мэндийн дээд жишгийн үйлчилгээг хүртэх эрхтэй. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд нь энэ эрхийн салшгүй хэсэг мөн.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр эрүүл мэндийн дээд жишгийн үйлчилгээ хүртэх эрхийг нь бүх хүнд хангахын тулд бүх шаардлагатай эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтгүйгээр хүн бүр эрүүл мэндийнхээ баримт түүхийг мэдэх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой эрүүл мэндийн байгууллага, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг хүртэх эрхээр хүн бүрийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

В. Эмнэлгийн халамж, бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ нь хүмүүсийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг авч үзэлгүйгээр, мөн түүнд нь үндэслэн ялгаварлан гадуурхалтгүйгээр тэдний хэрэгцээнд тулгуурлан эрүүл мэндийн байдлыг нь сайжруулахад чиглэгдсэн байхыг, мөн эрүүл мэндийн байдлын тухай баримт түүхийн нууцыг чандлан хадгалахыг хангах ёстой.

Г. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой аливаа ялгаварлан гадуурхалт, мухар сүсэг болон бусад хүчин зүйлс нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх үр дагавартай тул эдгээрийг дуусгавар болгоход чиглэсэн хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ёстой.

Д. Эмчилгээ, халамжийн талаар шийдвэр гаргахдаа хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлдээ үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр бүрэн мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргахыг нь хангах ёстой.

Е. Бүх төрлийн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд, боловсрол, урьдчилан сэргийлэлт, халамж, эмчилгээний хөтөлбөр болон үйлчилгээ нь өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг хүндэтгэсэн, ялгаварлан гадуурхалтгүйгээр бүх хүмүүст хүртээмжтэй байхыг хангах ёстой.

Ё. Хүйсийн шилжилттэй холбоотой бие махбодоо өөрчлөхийг хүссэн хүмүүст шаардлага хангахуйц, үл ялгаварлан гадуурхсан эмчилгээ, халамж, дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хангах ёстой.

Ж. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид нь үйлчлүүлэгчийн ханийг гэр бүлийн ойр дотны гишүүн хэмээн үзэхийг багтаан үйлчлүүлэгч ба түүний ханийг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн ялгаварлан гадуурхалтгүй харьцахыг хангах ёстой.

З. Бүх хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг хүндэтгэн, тэдэнд эрүүл мэндийн шаардлага хангахуйц дээд жишгийн үйлчилгээг хүргэх эрүүл мэндийн салбарт ажиллаж буй бүх хүнийг чадваржуулахад шаардлагатай боловсрол, сургалтын хөтөлбөр, бодлогыг боловсруулж нэвтрүүлэх ёстой.

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ САЛБАРЫН БУРУУ, ЗОХИСГҮЙ ҮЙЛДЛЭЭС ХАМГААЛАГДАХ ЭРХ

ЗАРЧИМ

18

Хэнийг ч бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн аливаа хэлбэрийн эмчилгээ эсвэл сэтгэлзүйн эмчилгээ, амлбар болон туршилтад албадан оруулах ёсгүй бөгөөд хүчээр эмнэлгийн байгууламжид хорих ёсгүй. Өөрөөр ангилж тодорхойлсон байлаа ч хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл нь эрүүл мэндийн асуудал буюу өвчин биш бөгөөд үүнийг эмчилж, эдгээж, эсвэл дарагдуулах боломжгүй.

Улс орнууд:

А. Соёл уламжлал эсвэл бусад эх сурвалжаас улбаатай биеэ авч явах байдал, бие махбодын гадаад төрх болон хүйсийн хэм хэмжээтэй холбоотой хэвшмэл ойлголт болон бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэсэн эмнэлгийн буруу, зохисгүй үйлдлээс хүмүүсийг бүрэн хамгаалахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Хүүхдийн төлөө хийгдэх бүх үйл ажиллагаанд хүүхдийн сайн сайхны төлөөх эрх ашгийг нь эн тэргүүнд тавих зарчмын дагуу нас, хөгжлийг нь харгалзан хүүхэд бүрэн мэдээлэл авсандаа үндэслэн чөлөөтэй, ухамсартайгаар зөвшөөрөөгүй тохиолдолд хүүхдэд аль нэг хүйсийн баримжааг тулгах зорилготой, бие махбодыг нь эргэлт буцалтгүй өөрчлөх эмнэлгийн ажилбарт хүүхдийг оруулахгүй байхыг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

В. Аливаа хүүхэд эрүүлийг хамгаалах салбарын буруу, зохисгүй үйлдэлд өртөхөөс, эсвэл өртөх эрсдэлд орохоос сэргийлэх хүүхэд хамгааллын тогтолцоонуудыг бий болгох ёстой.

Г. Өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийг ХДХВ/ДОХ эсвэл бусад өвчний вакцин, эмчилгээ эсвэл антибиотиктэй холбоотой ёс зүйгүй эсвэл сайн дурын бус эмнэлгийн ажилбар, судалгаа шинжилгээнд оруулахаас хамгаалагдсан байхыг хангах ёстой.

Д. Ийм төрлийн эрүүлийг хамгаалах салбарын буруу, зохисгүй үйлдлийг хөхиүлэн дэмжсэн, эсвэл ямарваа байдлаар эдгээр зүй бус үйлдэл гарахад хүргэсэн хөгжлийн туслалцааны хүрээнд хийгдэж буй төслүүдийг багтаан эрүүл мэндийг санхүүжүүлэх тогтолцоо, хөтөлбөрүүдийг дахин хянаж, өөрчлөх ёстой.

Е. Аливаа эмнэлгийн буюу сэтгэлзүйн эмчилгээ, зөвлөгөө нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг эмчлэгдэх, эдгэрэх эсвэл дарагдуулах ёстой эрүүл мэндийн асуудал хэмээн илт эсвэл далдуур тооцохгүй байхыг хангасан байх ёстой.

ЗАРЧИМ

19

ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ТҮҮНИЙГЭЭ ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн бүр үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Үүнд үг яриа, биеэ авч явах байдал, хувцаслалт, бие махбодын

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

өвөрмөц байдал, нэрийн сонголт болон бусад зүйлээр илрэх хувь хүний өөрийгөө илэрхийлэх байдал, мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад замаар ямар нэгэн хязгаарлалтгүйгээр хүний эрх болон бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой бүх төрлийн мэдээлэл, үзэл бодлыг эрэлхийлэх, хүлээж авах болон бусдад түгээх эрх чөлөө багтана.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн тухай мэдээлэл, үзэл бодлоо хуваалцах, бусдаас хүлээж авах, түүнчлэн аюулгүй бэлгийн харьцааны тухай мэдээлэл авах, түгээн дамжуулах, хуралд оролцох, зохион байгуулах, нэвтрүүлэг цацах, хэвлэн нийтлүүлэх, хууль эрхийн талаар нөлөөллийн үйл ажиллагаа явуулах зэрэг бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэхийг нь хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Төрийн хэвлэл мэдээллийн байгууллагууд болон тэдний гаргаж буй мэдээлэл, нэвтрүүлэг, мэдэгдэл нь бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийг хөндсөн асуудлуудын хувьд ялгаварлан гадуурхалтын шинж чанар агуулаагүй, олон ургальч үзэлд суурилсан байхыг, мөн ийм байгууллагуудын боловсон хүчнийг ажилд авах болон албан тушаал дэвшүүлэх бодлого нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхаагүй байхыг хангах ёстой.

В. Үг яриа, биеэ авч явах байдал, хувцаслалт, бие махбодын өвөрмөц байдал, нэрийн сонголт болон бусад зүйлээр илрэх хувь хүний илэрхийлэмжийн эрхийг нь бүрэн дүүрэн хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Г. Өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн тухай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа нийгмийн хэв журам, ёс суртахуун, нийтийн эрүүл мэнд болон нийгмийн аюулгүй байдлын үзэл санаа гэсэн шалтгааныг хэрэглэхгүй байхыг хангах ёстой.

Д. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл бүхий хүмүүсийн эрх, эрх чөлөөг зөрчихгүй байхыг хангах ёстой.

Е. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран бүх хүн мэдээлэл авах, үзэл санаагаа чөлөөтэй илэрхийлэх, мөн олон нийтийн хэлэлцүүлэг мэтгэлцээнд оролцох тэгш эрхтэй.

ЗАРЧИМ 20 ТАЙВАН ЗАМААР ЭВЛЭЛДЭН НЭГДЭХ ЭРХ

Хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран тайван замаар жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхтэй. Хүмүүс ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн үндсэн дээр эвлэлдэн нэгдэх, өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах, тэдний хооронд ба тэдний талаарх мэдээллийг түгээх зорилгоор эвлэлдэн нэгдэх эрхтэй ба эвлэлдэн нэгдсэн байдлаа хуулиар хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалталтад өртөлгүйгээр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар хэлэлцэхийн тулд тайван замаар эвлэлдэн нэгдэх, үйл ажиллагаа зохион байгуулах, цугларах болон нөлөөллийн ажил хийх эрх, мөн эдгээр эвлэлдэн нэгдсэн байдлаа хуулиар хүлээн зөвшөөрүүлэх эрхийг нь хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авч, хэрэгжүүлэх ёстой.

Б. Өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн тухай мэдээлэл өгөхтэй, авахтай холбоотой тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхийг нь хязгаарлахын тулд нийгмийн хэв журам, ёс суртахуун, нийтийн эрүүл мэнд болон нийгмийн аюулгүй байдлын үзэл санаа зэрэг шалтгааныг хэрэглэхгүй байхыг хангах ёстой.

В. Ямар ч нөхцөлд тайван замаар эвлэлдэн нэгдэх эрхийг нь хүмүүсийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн зөрчих ёсгүй бөгөөд энэ эрхээ эдэлж буй хүмүүсийн эсрэг хүчирхийлэл, зүй бус үйлдэл гарахаас сэргийлж цагдаа болон бусад хамгаалалтаар хангах ёстой.

Г. Ийм хамгаалалтыг үзүүлэх ёстой хууль сахиулах эрх мэдэл бүхий байгууллагууд болон холбогдох ажилтнуудад зориулж сургалт мэдээллийн хөтөлбөрүүдийг зохион байгуулах ёстой.

Д. Сайн дураар эвлэлдэн нэгдсэн бүлгүүдийн тухай мэдээллийн нууцыг илчлэх журам нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар эвлэлдэн нэгдсэн бүлгүүд, тэдний гишүүдийг ялгаварлан гадуурхахуйц үр дүнд хүргэхгүй байхыг хангах ёстой.

ЗАРЧИМ

ИТГЭЛ ҮНЭМШИЛ, СҮСЭГ БИШРЭЛТЭЙ БАЙХ, ШАШИН ШҮТЭХ ЭРХ

21

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран хүн бүр итгэл үнэмшил, сүсэг бишрэлтэй байх, шашин шүтэх эрхтэй. Улс орнууд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн хүмүүсийг хуулиар эрх тэгш байдлаар хамгаалахгүй байх, эсвэл тэднийг ялгаварлан гадуурхах хууль тогтоомж, бодлого, үйлдлээ зөвтгөхийн тулд эдгээр эрхийг хэрэглэх ёсгүй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үл хамааран хүн шашны болон шашны бус итгэл үнэмшилтэй байх, итгэл үнэмшлээ ганцаар болон бусадтай хамтаар илэрхийлэх, итгэл үнэмшилд нь хөндлөнгөөс оролцохоос ангид байх, итгэл үнэмшлийг албадан тулгахаас ангид байх эрхийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой олон төрлийн үзэл бодол, итгэл үнэмшил, санал бодлыг хүний эрхэд харшилсан байдлаар илэрхийлэхгүй, хэрэгжүүлэхгүй, сурталчлахгүй байхыг хангах ёстой.

ЧӨЛӨӨТЭЙ ЗОРЧИХ ЭРХ

ЗАРЧИМ

22

Аливаа улс оронд хуулийн дагуу байгаа хүн бүр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран тухайн улсын хил хязгаарын дотор чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгож эрхтэй. Өөрийнх нь улсыг оролцуулан аливаа улсад нэвтрэх, гарах эсвэл буцаж ирэхийг нь хязгаарлах эсвэл саад учруулахдаа хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг нь үндэс болгох ёсгүй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран хүн бүр чөлөөтэй зорчих, оршин суух газраа сонгох эрхийг

нь хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

ЗАРЧИМ
23

ОРОГНОЛ ХҮСЭХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой мөрдлөгө хавчлагыг оролцуулан бүх төрлийн мөрдлөгө хавчлагаас дүрвэж буй хүн бүр бусад улсад орогнол хүсэх, орогнох эрхтэй. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэсэн эрүү шүүлт, мөрдлөгө хавчлага, эсвэл бусад харгис, хүнлэг бус эсвэл доромжилсон харьцаа болон шийтгэл хүлээх үндэслэл бүхий айдастай хүнийг аливаа улсаас албадан гаргах, бусад улсад шилжүүлэн өгөх ёсгүй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэсэн эрүү шүүлт, мөрдлөгө хавчлага, эсвэл бусад харгис, хүнлэг бус эсвэл доромжилсон харьцаа болон шийтгэл хүлээх үндэслэл бүхий айдастай хүнд дүрвэгчийн статус, орогнол олгох үндэслэл хэмээн хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хууль тогтоомжоо шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр тусгах ёстой.

Б. Ямарваа бодлого журам, үйлдэл нь орогнол хүсэгчдийг бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн ялгаварлан гадуурхахгүй байхыг хангах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн эрүү шүүлт, мөрдлөгө хавчлага болон харгис, хүнлэг бус эсвэл доромжилсон аливаа хэлбэрийн харьцаа эсвэл шийтгэл хүлээх үндэслэл бүхий айдастай хүнийг аливаа улсаас албадан гаргах, бусад улсад шилжүүлэн өгөхгүй байхыг хангах ёстой.

ЗАРЧИМ
24

ГЭР БҮЛ ҮҮСГЭХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран хүн бүр гэр бүл үүсгэх, гэр бүл болох эрхтэй. Гэр бүлийн олон хэлбэр бий. Гэр бүлийн аль ч гишүүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн ямар ч гэр бүлийг ялгаварлан гадуурхах ёсгүй.

Улс орнууд:

А. Хүүхэд үрчлэх эсвэл донорын үр суулгахыг оролцуулан гуравдагч

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

этгээдийн оролцоо тусламжтайгаар хүүхэдтэй болох замаар гэр бүл үүсгэх эрхийг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр ялгаварлан гадуурхалгүй хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

Б. Удам угсаа эсвэл гэрлэлтээр тодорхойлогдоогүй гэр бүлийн олон хэлбэрийг хууль тогтоомж, бодлого журмаар хүлээн зөвшөөрөх нөхцөлийг бүрдүүлж, гэр бүлийн аль ч гишүүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэн ямар ч гэр бүлийг гэр бүлийн болон бусад нийгмийн халамж тэтгэмж, хөдөлмөр эрхлэлт, цагаачлалтай холбоотойгоор ялгаварлан гадуурхахгүй нөхцөлийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

В. Төрийн эсвэл хувийн секторын нийгмийн халамжийн байгууллага, шүүх, захиргааны байгууллага, хууль сахиулах байгууллагаас гаргасан хүүхэдтэй холбоотой бүх үйл ажиллагаа эсвэл шийдвэрт хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд тавих ёстой ба үүнд тухайн хүүхдийн эсвэл түүний гэр бүлийн аль нэг гишүүний эсвэл бусад хүний бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг ийм эрх ашигт харш хэмээн үзэхгүй байх нөхцөлийг хангахын тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

Г. Хүүхэдтэй холбоотой бүх үйл ажиллагаа эсвэл шийдвэрт хувийн үзэл бодлоо төлөвшүүлэх чадамжтай хүүхдэд өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгож, тухайн хүүхдийн нас, хөгжилд нь тааруулан ийм үзэл бодолд нь зохих ач холбогдол өгөх нөхцөлийг хангах ёстой.

Д. Ижил хүйсийн иргэний гэрлэлт болон бүртгэлтэй хамтын амьдралыг хүлээн зөвшөөрдөг улс оронд эсрэг хүйсийн гэрлэсэн болон бүртгэлтэй хосуудад олгох аливаа эрх, онцгой эрх, үүрэг, эсвэл тэтгэмжийг ижил хүйсийн гэрлэсэн болон бүртгэлтэй иргэдэд мөн адил олгох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

Е. Эсрэг хүйсийн гэрлээгүй иргэдэд олгох аливаа эрх, онцгой эрх, үүрэг, эсвэл тэтгэмжийг ижил хүйсийн гэрлээгүй иргэдэд мөн адил олгох нөхцөл бүрдүүлэхийн тулд шаардлагатай бүх эрх зүйн, захиргааны болон бусад арга хэмжээг авах ёстой.

Ё. Гэрлэх эсвэл хамтран амьдрахыг хүсч буй хүмүүсийг зөвхөн чөлөөтэй, бүрэн зөвшилцсөний үндсэн дээр л гэрлэх эсвэл хуулиар хүлээн зөвшөөрсөн бусад хамтын амьдралыг зохиох нөхцөлөөр хангах ёстой.

ЗАРЧИМ

25

ОЛОН НИЙТИЙН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр иргэн бүр сонгуульд нэр дэвших болон бусад аргаар төрийн үйл хэрэгт оролцох, ахуй амьдралд нь нөлөөлөх бодлого журам боловсруулахад оролцох, бүх түвшиний нийтийн үйлчилгээг эрх тэгш хүртэх, цагдаагийн болон цэргийн алба зэрэг төрийн албанд ажил эрхлэх зэргээр олон нийтийн амьдралд оролцох эрхтэй.

Улс орнууд:

А. Хүн бүрийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг бүрэн хүндэтгэж, түүнд нь үндэслэн ялгаварлан гадуурхахгүйгээр бүх түвшиний төрийн үйлчилгээг тэгш хүртэх, цагдаагийн болон цэргийн алба зэрэг төрийн албанд ажил эрхлэх зэргээр олон нийтийн болон улс төрийн амьдрал, хэрэгт оролцох эрхийг бүрэн хангахын тулд хууль тогтоомжид дүгнэлт хийх, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах ёстой.

Б. Олон нийтийн амьдралд оролцоход нь саад болдог, хязгаарладаг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хэвшмэл ойлголт, мухар сүсгийг таслан зогсоохын тулд зохих бүх арга хэмжээг авах ёстой.

В. Хүн бүрийн бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийг бүрэн хүндэтгэж, түүнд нь үндэслэн ялгаварлан гадуурхахгүйгээр ахуй амьдралд нь нөлөөлөх бодлого журмыг боловсруулахад хүн бүрийн оролцох эрхийг хангах ёстой.

ЗАРЧИМ

26

СОЁЛЫН АМЬДРАЛД ОРОЛЦОХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран хүн бүр соёлын амьдралд чөлөөтэй оролцох, соёлын оролцоогоор дамжуулан бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллийн ялгаатай байдлаа илэрхийлэх эрхтэй.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс үл хамааран, түүнийг нь бүрэн хүндэтгэн, бүх хүмүүст соёлын амьдралд оролцох боломж нөхцөлийг нь бүрдүүлэхийн тулд эрх зүйн, захиргааны болон бусад бүх арга хэмжээг авах ёстой.

Б. Тухайн улсад байгаа бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлыг оролцуулан өөр үзэл бодол баримталдаг бүлгүүдийн хоорондын харилцан ойлголцол, хүндэтгэлийг эдгээр зарчимд дурьдсан хүний эрхтэй нийцүүлсэн байдлаар хөхиүлэн дэмжих ёстой.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ЭРХ ЗАРЧИМ

27

Бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэн ялгаварлан гадуурхалтад өртөлгүйгээр хүн бүр ганцаараа эсвэл бусадтай хамтран хүний эрхийг дотоодын болон олон улсын түвшинд хамгаалах, хангахыг хөхиүлэн дэмжих эрхтэй. Үүнд бэлгийн өөр өөр чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн эрх, хүний эрхийн шинэ хэм хэмжээг боловсруулан хэлэлцэж, тэдгээрийг хүлээн зөвшөөрүүлэхийг сурталчлах, хангахад чиглэсэн үйл ажиллагаа багтана.

Улс орнууд:

А. Хүний эрх, ялангуяа бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хангахад чиглэсэн үйл ажиллагаанд тааламжтай орчин бүрдүүлэхийн тулд эрх зүйн, захиргааны болон бусад шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

Б. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар ажилладаг болон бэлгийн өөр өөр чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүний эрх хамгаалагчдын эсрэг чиглэсэн үйл ажиллагаа, эсвэл тэдний эсрэг зохион байгуулалттай кампанит ажилтай тэмцэхийн тулд зохих бүх арга хэмжээг авах ёстой.

В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэл, хөхиүлэн дэмждэг хүний эрхийн асуудлаас нь үл хамааран хүний эрх хамгаалагчид ялгаварлан гадуурхалтад өртөлгүй үндэсний болон олон улсын хүний эрхийн байгууллагуудтай холбогдох, оролцох, харилцаа холбоотой ажиллах зэрэг эрхийг нь хангах ёстой.

Г. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллийн асуудлаар ажилладаг хүний эрх хамгаалагчдын хүний эрхийн төлөө явуулах үйл ажиллагааных нь хариуд аливаа хүчирхийлэл, сүрдүүлэг, хариу цохилт, де факто болон де юре ялгаварлан гадуурхал, дарамт, төрийн эсвэл төрийн бус албанаас ногдуулах аливаа дур зоргын үйл ажиллагаанаас хамгаалагдсан байх ёстой. Ийм халдлагаас

хамгаалагдсан байхыг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээс нь үл хамааран ямар ч асуудлаар ажиллаж буй хүний эрх хамгаалагчдад хангах ёстой.

Д. Бэлгийн өөр өөр чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хүний эрхийг үндэсний болон олон улсын түвшинд хөхиүлэн дэмжиж, хамгаалдаг байгууллагуудыг хүлээн зөвшөөрч итгэмжлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой

ЗАРЧИМ

28

ГОМДОЛ ХОХИРЛОО БАРАГДУУЛУУЛАХ ЭРХ

Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн зөрчлийг оролцуулан хүний эрхийн бусад зөрчлийн хохирогч үр дүнтэй, хангалттай, зохистой байдлаар хохирлоо барагдуулуулах эрхтэй. Бэлгийн өөр өөр чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хохирлыг барагдуулах, эсвэл ийм зорилгоор авч хэрэгжүүлсэн хангалттай арга хэмжээ нь гомдол хохирлоо барагдуулуулах эрхийн салшгүй нэг хэсэг болно.

Улс орнууд:

А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлдээ үндэслэн хүний эрхийн зөрчлийн золиос болсон хохирогчдыг нөхөн олговор, нөхөн төлбөр, нөхөн сэргээлт, сэтгэл ханамж, дахин давтагдахгүй гэсэн баталгаа, зохих аливаа бусад арга хэрэгслээр дамжуулан гомдлоо бүрэн барагдуулуулах нөхцөл боломжоор хангахын тулд хууль тогтоомж, бодлого журамд өөрчлөлт оруулах болон бусад замаар эрх зүйн шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой.

Б. Хохирлыг цаг алдалгүй барагдуулах нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

В. Хохирол, гомдол барагдуулах үр дүнтэй тогтолцоо, хохирол барагдуулах жишгийг тогтоож, бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн хүний эрхийн бүх төрлийн зөрчлийн талаарх сургалтанд бүх ажилтан хамрагдсан байхыг хангах ёстой.

Г. Хохирол, гомдлоо барагдуулах үйл явцын талаарх шаардлагатай мэдээлэл бүх хүнд хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

Д. Хохирлоо нэхэмжлэх зардлыг төлөх чадваргүй этгээдэд санхүүгийн туслалцаа үзүүлэх, хохирлыг барагдуулахад тулгарах санхүүгийн эсвэл бусад аливаа саад тогторыг арилгахыг хангах ёстой.

Е. Эдгээр зарчимтай нийцүүлэн хүний эрхийн олон улсын жишгийг хүндэтгэх, хэрэгжүүлэх, баримтлахыг хөхиүлэн дэмжиж, бэлгийн

чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтын эсрэг арга хэмжээ авахын тулд мэргэжлийн байгууллагууд, хүний эрхийг зөрчигчид, нийтийн боловсролын бүх түвшинд багш, оюутнуудад чиглэсэн арга хэмжээ зэрэг сургалт сурталчилгаа, мэдээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой.

ХАРИУЦЛАГА

ЗАРЧИМ 29

Эдгээр зарчимд туссан эрхийг оролцуулан хүний эрх нь зөрчигдсөн хүн бүр түүний эрхийг зөрчсөн байдалд шууд ба шууд бус байдлаар буруутай этгээд нь төрийн албан хаагч мөн эсэхээс үл хамааран тухайн буруутай этгээдийн хүний эрх зөрчсөнтэй нь тэнцэхүйц хариуцлага хүлээлгэхийг шаардах эрхтэй. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотойгоор хүний эрхийг зөрчсөн хүмүүсийг хэрхэвч ял шийтгэлээс чөлөөлөх ёсгүй.

Улс орнууд:

- А. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хүний эрхийг зөрчигсдөд хариуцлага хүлээлгэхийн тулд зохих, хүртээмжтэй, үр дүнтэй эрүүгийн, иргэний, захиргааны болон бусад журам процедур, хяналтын тогтолцоог бий болгох ёстой.
- Б. Хохирогчийн жинхэнэ эсвэл үзэгдэх бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд нь үндэслэн тэдний эсрэг үйлдсэн, мөн эдгээр зарчимд тусгасан гэмт хэргийг шуурхай, бүрэн дүүрэн мөрдөн шалгаж, зохих нотолгоо олдвол буруутай этгээдэд хэрэг үүсгэн, зохих ёсоор шийтгэхийг хангах ёстой.
- В. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоохын тулд хууль тогтоомж, бодлого журам боловсруулан сахиулахын тулд бие даасан, үр дүнтэй тогтолцоо, процедурыг бүрдүүлэх ёстой.
- Г. Бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэн хүний эрхийг зөрчсөн хүмүүст хариуцлага хүлээлгэхэд аливаа саад тогторыг арилгах ёстой.

НЭМЭЛТ ЗӨВЛӨМЖ

Нийгэм ба олон улсын хамтын нийгэмлэгийн бүх гишүүд хүний эрхийг хангах талаар үүрэг хариуцлага хүлээдэг. Тиймээс бид дараах зүйлийг зөвлөмж болгож байна. Үүнд:

А. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар эдгээр зарчмыг батлаж, дэлхий даяар эдгээр зарчмын хэрэгжилтийг хөхиүлэн дэмжиж, Хүний эрхийн дээд комиссарын газар бүх түвшиний үйл ажиллагаандаа эдгээр зарчмыг тусгах ёстой.

Б. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөл эдгээр зарчмыг баталж, эдгээр зарчмыг улс орнууд баримтлахыг хөхиүлэн дэмжих зорилгоор бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн хүний эрхийн зөрчилд бодитой анхаарал хандуулан, асуудлыг авч үзэх ёстой.

В. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн тусгай журмын дагуух ажлууд нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлд үндэслэсэн хүний эрхийн зөрчлийг зохих ёсоор анхаарч, эдгээр зарчмыг тус тусын эрх мэдэл, мандатын хүрээнд тусгах ёстой.

Г. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн зөвлөл 1996/ 31-р тогтоолын дагуу өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хүний эрхийг хөхиүлэн дэмжиж, хамгаалах зорилготой төрийн бус байгууллагуудыг хүлээн зөвшөөрч итгэмжлэх ёстой.

Д. Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн шинжээчдийн хороонууд эдгээр зарчмыг өөр өөрийн эрх мэдэл, мандатад нэгтгэн хэрэгжүүлж, улс орнуудын тайланг шалгах үйл явцдаа эрчимтэй тусгаж, зохистой тохиолдолд өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хувьд хүний эрхийн эрх зүйг хэрхэн хэрэглэх тухай ерөнхий тайлбар болон бусад тайлбарыг гаргах ёстой.

Е. Дэлхийн Эрүүл мэндийн Байгууллага болон НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотойгоор хэрхэн хүмүүсийн эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг хангаж, хүний эрх, нэр төрийг нь бүрэн хүндэтгэсэн байдлаар эрүүл мэндийн зохих үйлчилгээ, тусламж үзүүлэх тухай удирдамж боловсруулах ёстой.

Ё. НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхлэх дээд комиссар эдгээр зарчмыг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээсээ үүдэн мөрдлөгө хавчлагад өртсөн эсвэл мөрдлөгө хавчлагад өртөх үндэслэл

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

бүхий айдастай хүмүүсийг хамгаалж, эдгээр хүмүүс хүмүүнлэгийн туслалцаа болон бусад үйлчилгээ хүртэх, дүрвэгчийн статус авахтай холбоотойгоор хэний ч бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр нь ялгаварлан гадуурхахгүй байхыг хангах ёстой.

Ж. Хүний эрхийг гол асуудлаа болгосон бүсийн болон дэд бүсийн засгийн газар хоорондын байгууллагууд, мөн бүсийн шинж чанартай хүний эрхийн гэрээний хороод эдгээр зарчмыг хөхиүлэн дэмжих нь хүний эрхийн механизм, процедур болон бусад ажил, санаачлагын хүрээнд мандатаа хэрэгжүүлэхийн салшгүй хэсэг байхыг нь хангах ёстой.

З. Хүний эрхийн бүсийн шүүхүүд бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хэргүүдийг авч үзэхдээ зөвхөн хүний эрхийн гэрээ хэлэлцээрт хамаатай эдгээр зарчмыг эрчимтэй тусгах ёстой.

И. Үндэсний, бүсийн, олон улсын түвшинд ажилладаг төрийн бус байгууллагууд эдгээр зарчмыг өөр өөрийн тодорхой эрх мэдлийн хүрээнд хүндэтгэхийг хөхиүлэн дэмжих ёстой.

Й. Хүмүүнлэгийн байгууллагууд эдгээр зарчмыг хүмүүнлэгийн болон тусламжийн аливаа үйл ажиллагаандаа тусгаж, тусламж, бусад үйлчилгээг үзүүлэхдээ хүмүүсийг бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийллээр нь ялгаварлан гадуурхахгүй байх ёстой.

К. Хүний эрхийн үндэсний байгууллагууд эдгээр зарчмыг төрийн болон төрийн бус этгээдүүд бүгд хүндэтгэхийг хөхиүлэн дэмжиж, өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хүний эрхийг хөхиүлэн дэмжин, хамгаалах үйл ажиллагаандаа тусгах ёстой.

Л. Анагаах ухаан, эрүүгийн болон иргэний эрх зүйн зэрэг мэргэжлийн байгууллагууд, боловсролын салбар эдгээр зарчмыг эрчимтэй хэрэгжүүлэхийг хөхиүлэн дэмжихдээ өөрсдийн арга ажиллагаа, үйл ажиллагааны удирдамжаа эргэж харж, шинэчлэх ёстой.

М. Өөрсдийн хүний нөөцийн хувьд эдгээр зарчмыг хэрэгжүүлэх үүрэг, мөн эдгээр зарчмыг үндэсний болон олон улсын хэмжээнд хөхиүлэн дэмжихэд гүйцэтгэх чухал үүргээ ухамсарлан хувийн секторын байгууллагууд эдгээр зарчмыг хүндэтгэх нөхцөлийг бүрэлдүүлэх ёстой.

Н. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй холбоотой хэвшмэл буруу ойлголт хэрэглэхээс зайлсхийж, өөр өөр бэлгийн чиг баримжаа,

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

хүйсийн баримжаа илэрхийллийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөхийг хөхиүлэн дэмжиж, эдгээр асуудлын талаар олон нийтэд боловсрол олгох ёстой.

О. Засгийн газар болон хувийн санхүүжүүлэгч байгууллагууд өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад нь төрийн бус болон бусад байгууллагуудад санхүүгийн туслалцаа үзүүлэх ёстой.

ЭДГЭЭР ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖ нь хүний эрхийн олон улсын эрх зүйг өөр өөр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн амьдралд хэрхэн хэрэглэх тухай юм. Энд багтсан аль ч зүйлийг өөр өөр бэлгийн чиг баримжаа эсвэл хүйсийн баримжаа илэрхийлэлтэй хүмүүсийн олон улсын, бүсийн эсвэл үндэсний хууль, жишгийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн эрх, эрх чөлөөг хязгаарлан боогдуулсан хэлбэрээр тайлбарлах ёсгүй.

ХАВСРАЛТ

**ЖОГЖАКАРТЫН ЗАРЧИМД ГАРЫН ҮСЭГ
ЗУРСАН ХҮМУУС**

Филип Алстон (Австрали), НҮБ-ын шүүхийн гадуур, өчиггүй, зоргоор цаазлах асуудлын тусгай илтгэгч

Максим Анмегхичиан (Молдав), ИЛГА, Европын бүс

Мауро Кабрал (Аргентин), Аргентины Кордобагийн Үндэсний их сургуулийн судлаач, Олон улсын лесбиян, гей хүний эрхийн хороо

Эдвин Камерон (Өмнөд Африк), Өмнөд Африк, Бломфонтэйн хотын дээд шүүхийн шүүгч

Соня Онуфер Коррея (Бразил), Бразилийн салбар хоорондын ДОХ-ын нийгэмлэгийн судлаач, бэлгийн асуудлаарх бодлого хяналтын дэд дарга (шинжээчдийн хурлыг хамтран тэргүүлэгч)

Якин Эртюрк (Турк), НҮБ-ын эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудлын тусгай илтгэгч, Туркийн Анкара хотын Ойрх Дорнодын Техникийн их сургуулийн нийгэм судлалын тэнхимийн профессор

Элизабет Эватт (Австрали), НҮБ-ын Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн алагчлалыг утсгах хорооны гишүүн асан, НҮБ-ын Хүний эрхийн хорооны гишүүн асан, Олон улсын эрх зүйчдийн хорооны комиссионер асан

Пол Хант (Шинэ Зеланд), НҮБ-ын Хүрч болох дээд хэмжээний эрүүл мэндийн шижгээр эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудлын тусгай илтгэгч, Их Британийн Эссексийн их сургуулийн хуулийн тэнхимийн профессор

Асма Жахангир (Пакистан), Пакистаны Хүний эрхийн комиссын дарга

Мэйна Киай (Кени), Кенийн Хүний эрхийн комиссын дарга

Милун Котари (Энэтхэг), НҮБ-ын шаардлага хангахуйц орон байртай байх эрхийн асуудлын тусгай илтгэгч

Жудит Мескита (Их Британи), Их Британийн Эссексийн их сургуулийн Хүний эрхийн төвийн ахлах судлаач

Алис М.Миллер (Америкийн Нэгдсэн Улс), АНУ-ын Коламбийн их сургуулийн Хүний эрхийн хөтөлбөрийн дэд захирал, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн дэд профессор

Санжи Ммасеноно Монагенг (Ботсвана), Дээд шүүхийн шүүгч (Гамбийн

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

Бүгд Найрамдах Улс), Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн хорооны төлөөлөгч, эрүү шүүлт, бусад харгис, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах харьцааг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх тухай Роббен арлын удирдамжийг хэрэгжүүлэх хорооны дарга (Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн хороо)

Витит Мунтарбхорн (Тайланд), НҮБ-ын Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс дахь хүний эрхийн асуудлын тусгай илтгэгч, Тайландын Чулалонгкорны их сургуулийн эрх зүйн профессор (шинжээчдийн хурлыг хамтран тэргүүлэгч)

Лоренс Мют (Кени), Кенийн Хүний эрхийн хорооны төлөөлөгч

Манфред Новак (Австри), НҮБ-ын Эрүү шүүлт, харгис, хүнлэг бус, хүний нэр төрийг гутаан доромжилсон харьцаа, шийтгэлийн асуудлын тусгай илтгэгч, Олон улсын эрх зүйчдийн хорооны гишүүн, Австрийн Вена хотын их сургуульд хүний эрхийн профессор, Людвиг Болцмэний нэрэмжит Хүний эрхийн хүрээлэнгийн захирал

Ана Елена Обандо Мендоза (Коста Рика), феминист өмгөөлөгч, эмэгтэйчүүдийн хүний эрх хамгаалагч, олон улсын зөвлөх

Майкл О'Фларети (Ирланд), НҮБ-ын Хүний эрхийн хорооны гишүүн, Их Британийн Ноттингхэмийн их сургуулийн хүний эрхийн профессор, Хүний эрхийн хуулийн төвийн дэд захирал (Жогжакартын зарчмуудыг боловсруулах илтгэгч)

Сүнил Пант (Балба), Балбын Хөх очир нийгэмлэгийн ерөнхийлөгч, 2008 оноос хойш Балбын Парламентын гишүүн

Димитрина Петрова (Болгар), Тэгш эрх байгууллагын гүйцэтгэх захирал

Руди Мохамед Ризки (Индонези), НҮБ-ын Олон улсын эв санааны нэгдлийн асуудлын тусгай илтгэгч, Индонезийн Паджаджараны их сургуулийн Хуулийн тэнхмийн сургалтын албаны дэд эрхлэгч

Мэри Робинсон (Ирланд), Эрхээ хэрэгжүүлэх: ёс зүйт даяаршлын санаачлага байгууллагыг үндэслэгч, Ирландын Ерөнхийлөгч асан, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан

Невена Вуковик Сахович (Серб), НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны гишүүн, Сербийн Белград хотын Хүүхдийн эрхийн төвийн ерөнхийлөгч

Мартин Шайнин (Финланд), НҮБ-ын Хүний эрх болон алан хядлагыг эсэргүүцэх асуудлын тусгай илтгэгч, Үндсэн хуулийн болон олон улсын

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

хуулийн профессор, Финландын Або Академи их сургуулийн Хүний эрхийн хүрээлэнгийн захирал

Уан Янхай (Хятад), АИЖИ Үйл Ажиллагаа төслийн үндэслэгч, Бээжин хотын АИЖИШИНГ Эрүүл мэндийн боловсролын хүрээлэнгийн захирал

Стефен Уитл (Их Британи), Их Британийн Манчестер Метрополитан их сургуулийн Тэгш эрхийн хуулийн профессор

Роман Виеружевски (Польш), НҮБ-ын Хүний эрхийн хорооны гишүүн, Польшийн Познань дах Хүний эрхийн төвийн тэргүүн

Роберт Уинтемют (Канад, Их Британи), Их Британийн Лондон хотын Кингз коллежийн Хуулийн сургуулийн хүний эрхийн эрх зүйн профессор

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД

ЖОГЖАКАРТЫН ЗАРЧМУУД